

## БЭЛЧЭЭРИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ЭРХ АШГИЙН ЭРЭМБЭЭР ХАНДЬЯ


2023 оны 2-р сарын 3-ны өдөр GOGO.MN сайтад гарсан нийтлэл

УИХ-д өргөн барьсан Газрын тухай багц хуулийн төсөлд туссан бэлчээрийг нийтээр ашиглах тогтолцооны өнгөрсөн 30 жилийн баримт, судалгааны дүнг толилуульж байна.

Мал аж ахуйн өнөөгийн байдал, суурь шалтгаан. 2019 оны эцэст Монгол улс 71 сая мал тоолуулж, түүхэн дээд амжилт тогтоов. “Дэлхий дэлэгнэнэ”, “Хаяа багтвал бууж, хамар багтвал иднэ” гэдэг зарчмаар үнэгүй бэлчээрт малчин, мал бүхий иргэд, бөх, бөө, уяач... гээд бүгд л хошууран дайрч малаа өсгөсний нөгөө талд бэлчээрийн даац хэтрэн доройтох болов. 2020 оны байдлаар Монгол орны 110 сая га бэлчээрийн 74.7% цөлжилтөд өртсөний 19.8% нь хүчтэй цөлжиж, байгалийн аясаар эргэж сэргэхээргүй бэлчээрийн хэмжээ эрс нэмэгдэж байна.

Малаа өсгөөд малчид, МАА-н салбар хожив уу гэвэл үгүй. Бэлчээрийн даац хэтэрснээр мал тэжээлийн архаг дутагдалд орж, давжааран ашиг шим нь буурахын зэрэгцээ ган, зуд, өвчлөл, уур амьсгалын өөрчлөлтөд нэн өртөмхий болж, үүнийг дагаад МАА-н өрсөлдөх чадвар, малчдын орлого буурч байна.

### Малын тоо ба тэжээлийн хангамж, 2010-2020 онд



Зуд, ган мэт байгалийн гамшигт малчдын амьжиргаа нэрвэгдсээр байна. 2009-2010 оны өвөл-хаврын зудад улсын хэмжээнд 9.7 сая мал хорогдож, бэлчээрийн ачаалал хэтэрснийг “байгаль зохицуулж” байв. 2009-2010 оны ган-зудын дараа тэжээлийн хангамж сайжирч, тухайн үед байсан 35 сая малд хангалттай хүрэлцэхээр байжээ.

Гэвч малын тоо өссөнөөр 2020 он гэхэд тэжээлийн хангамж шаардагдах хэмжээний дөнгөж 36 хувь болтлоо буурч, нэг хонины идэх тэжээлийг 2.7 хонь хувааж идэж, дутуу хооллолт 64% хүрээд байна. 1961 онд борлуулсан үхрийн амьдын жин 248 кг, оны эхний нэг үнээнээс үйлдвэрлэх сүү 344 литр байсан бол 1991 онд эдгээр үзүүлэлт 245 кг, 323 литр болж буурсан, үүнээс хойш улсын статистик үзүүлэлтээс хасагдаж, бүр хэмжихээ ч байсан юм. Эрдэмтдийн судалгаагаар бэлчээрийн доройтлоос шалтгаалан хонины амьдын жин 48-с 44 кг, ямааных 35-с 33 кг болж, хонины ноос, ямааны ноолуурын гарц 2-8%-р буурсан гэсэн дүн гарчээ. Зөвхөн эдгээр гуравхан үзүүлэлтээр тооцоход малын ашиг шим буурснаас малчин өрхийн орлогын алдагдал жил бүр 2.6 сая төгрөг, улсын хэмжээнд 368 тэрбум төгрөг болж байна.

Тэжээлийн архаг дутагдал бүтээгдэхүүний чанарт ч нэн сөргөөр нөлөөлж байгаа нь гулуузны жинд

өөхний хувийн жин түрж, махны хувийн жин багассанаар илэрч экспортын зах зээлд үнэлгээ нь унаж байна. Дан ганц хонин дээр тооцож үзэхэд малчдын алдагдсан боломж амьдын жин буурсны 14%, гулуузны чанар муудсаны 33%, нийт 42% болж, бүтэн тэжээлтэй байх үеийн хонины орлоготой харьцуулбал 58% болж буурсан байна.

**Бэлчээрийн даац хэтрэлт, тэжээлийн архаг дутагдлаас малын ашиг шим, үнэ цэнэ буурч байгаа нь**



Өөрөөр хэлбэл өнөөдрийн 31 сая хонь дүүрэн идэштэй байх үеийн 18 сая хонины ашиг шимийг л өгч байгаа хэрэг юм.

Ийнхүү жалгын нэг тарж, малаа өсгөх гэж хоёр зудын хооронд гадаа гандаж, хөдөө хөхрөөд үр дүнд нь хожсон зүйлгүй, харин ч бэлчээрээ талхалж, дээр нь отрын бэлчээрээ үгүй хийснээс дараагийн ган, зудаар бүр ч илүү хохирдог чөтгөрийн тойргоос малчдыг гаргаж, МАА-н салбарыг тогтвортой хөгжлийн замд хэрхэн оруулах вэ гэдэг асуулт хариулт нэхэж байна.

Бэлчээрийг нийтээр дундаа ашиглаж нөхцөлд даацыг оновчтой хэмжээнд барих ямар ч боломжгүй юм. Оновчтой даац барих нь бүү хэл, ашиглалтын хил заагаа тогтоодоггүй тул бэлчээрийн даац хэтэрсэн эсэхийг нь хэмжих ч боломжгүй юм. Малчдын одоогийн ашиглаж буй улирлын бэлчээрт нь бариулан хил заагийг хөршүүдтэй нь зөвшилцөн тогтоож, бэлчээрийн даацыг нь хэмжиж, түүнийг хэтрүүлэхгүй байх хариуцлагыг гэрээгээр зохицуулах бүрэн боломжтой болохыг төсөл, хөтөлбөрүүдийн үр дүн харуулаад байна.

Бэлчээр ашиглалтын ямар тогтолцоо уул уурхайн хөгжлийг тэтгэх вэ. Нийтээр дундаа ашиглах тогтолцоо нь уул уурхайн салбарыг тэлэхэд эерэг нөлөөтэй гэвэл эндүүрэл болохыг баримт нотолж байна.

Оюу толгойн уурхайн ашиглалтын лицензтэй талбай, хил хүртэлх авто зам, онгоцны буудал, ус дамжуулах шугам зэрэг уурхайтай холбоотой дэд бүтцийн байгууламжуудын туршлагаас харвал нийтээр дундаа ашиглах тогтолцооны нөхцөлд нөлөөлөлд өртсөн малчин өрхийг маргаангүй, нэг мөр, зөв тодорхойлсны үндсэн дээр нөхөн олговор олгох асуудал ихээхэн төвөгтэй болох нь харагдсан юм.

Энэ нь дээрх байгууламжуудыг тойрсон малчдын улирлын болон отрын бэлчээр ашиглалтын хил зааг тодорхойгүйгээс болсон бөгөөд тодорхой хил зааг бүхий гэрээгээр ашиглах хувилбартай харьцуулбал нэн олон тооны малчин өрхийн гомдлыг барагдуулах нөхцөлд орсноороо эдийн засгийн хувьд ч нэн илүү өртөгтэй болсон байна.

Эзэмшүүлэх, гэрээгээр ашиглуулах ойлголтын тухай. Газрыг эзэмшүүлэх (Монголчуудад), гэрээгээр ашиглуулах (гаднынханд) хэмээн хоёр салгаж орхисон ойлголт нь зах зээл хөгжсөн орнууд дахь түрээслэх буюу лизинг (lease, leasing) гэдэг ойлголттой дүйнэ. Зорилго нь газрын нөөцийг зохистой ашиглах харилцааг өмчлөгч, ашиглагчийн эрх, үүргээр зохицуулахад чиглэдэг. Ашиглагчийн гол үүрэг нь газрын чанарыг талхлан доройтуулахгүй байхад чиглэдэг бол өмчлөгчийн үүрэг нь ашиглагчийн зүгээс үүргээ биелүүлэх боломж, нөхцөлийг нь хангахад оршино. Тухайлбал, цаг агаар хэвийн нөхцөлд гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт бусдын мал орж талхлах, уул уурхай зэрэг бусад ашиглалтын зүгээс хохирол учруулахаас сэргийлэх, зөрчил маргааныг шийдвэрлэх үүргийг өмчлөгч буюу төр хүлээнэ. Бэлчээрийг үе уламжлан албан бусаар эзэмшиж ашиглаж ирсэн Монгол орны нөхцөлд бэлчээрийг гэрээгээр ашиглуулна гэдэг нь малчдын албан бус эрхийг цаасан дээр буулгаж, баталгаажуулна гэсэн үг. Өөрөөр хэлбэл малчдын дутуу эдлээд байгаа эрхийг нь гүйцээж, хамгаалахыг хэлээд байгаа юм. Энэ нь мал аж ахуйг бүтээмж өндөртэй, өрсөлдөх чадвартай, тогтвортой хөгжлийн замд оруулах нийтийн эрх ашигт нийцэж байгаа юм.

Гэрээгээр ашиглуулснаар ямар эрх ашиг хожих вэ. Хөгжлийн гол хөдөлгүүр нь технологийн дэвшил байдаг. **Тэгвэл манай мал аж ахуйн салбарын хөгжил зогсонги болсны үндсэн шалтгаан нь малын эзэн болсон малчны зүгээс технологийн дэвшил нэвтрүүлэх сонирхлын механизмыг нь бий болгоогүйд л оршино.** Үүний шалтгаан нь энгийн. Өөрт байгаа боломжуудаас хамгийн хямдыг нь сонгож ашиг, орлогоо нэмэгдүүлэх нь зах зээлийн эдийн засгийн хууль. Бэлчээр, түүн дээр байгаа ус, хужир мараа гээд аливаа нөөцийг үнэ төлбөргүй ашигладгийн зэрэгцээ даацыг нь хэтрүүлж талхалсан ч ямар ч хариуцлага хүлээдэггүй тогтолцоо малчдад үйлчилж байна. Ийм нөхцөлд малынхаа толгойн тоог өсгөөд л суух нь малчинд амар, хямд байгаа хэрэг. Мал эмнэлэг, малын чанар, өвс тэжээл, эрсдэлтэй тэмцэх, шинэ технологи, инновац, бүтээгдэхүүний чанар гэж толгойгоо өвтгөж, илүү зардал гаргаад яах юм. Яах вэ зүгээр өгвөл аваад л хэвтэж байя, сүх далайтал үхэр амар гэгчээр зуд болтол ч хаа юм, төр, засаг гэж нэг юм байна, туслах байлгүй гэсэн сэтгэлгээ ноёлж байна/1980-аад оны сүүлээр 1 хонин толгойд 10 гаруй кг тэжээл нэгжтэй тэнцэх нэмэгдэл тэжээл бэлтгэж байсан бол 2020 онд 6.8 кг болсон/. **Дүгнэж хэлбэл малчин хүний өнөөгийн амьжиргааны арга нь аж ахуйгаа эрхлэх дэвшилтэт аргыг нэвтрүүлэх сонирхолгүй болгож, үл хөгжихүйн гинжинд хүлээд байна.** Нөөцийн эдийн засгийн ухаанаар авч үзвэл мал аж ахуйн үйлдвэрлэлийн зардал нь тухайн малчин өрхийн өөрийн гаргасан хүн хүч, тэжээл, эм тарилга, тээвэр гэх мэт "дотоод" зардал, "гадаад" зардлын нийлбэрээс бүтнэ. Гадаад зардал нь бэлчээрийг ашигласны болон түүнд хор хохирол учруулсан бол тэр хохирлын хэмжээгээр нийгэмд учирч байгаа зардал юм. Гадаад зардлыг малчин үүрэхгүй байгаа учраас ямар хэмжээтэй гарах нь сонирхлыг нь нэг их татахгүй. Энэхүү гадаад зардлыг малчны сонирхлын хүрээнд хэрхэн оруулж ирж, бэлчээртээ өөриймсөг ханддаг, даацыг нь хамгаалж, сайжруулдаг, хэтрүүлж талхалсан бол эдийн засгийн хариуцлага хүлээдэг, ингэснээр малын тоог өсгөх биш харин чанар, бүтээмжийг сонирхдог болгох вэ гэдэгт асуудлын гол оршиж байгаа бөгөөд шийдэх гарц нь бэлчээрийг гэрээгээр ашиглуулах явдал юм.

Бэлчээрээ гэрээгээр ашиглаж, эрх ашгаа хамгаалах сонирхол малчдын дийлэнхийг бүрдүүлдэг ядуу, дунд бүлгийнхний дунд давамгайлж байгаа нь олон тооны судалгаа, баримтаар нотлогдсон зүйл. 2007 онд НҮБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр ХХААЯ-с нийт улс орныг хамруулан явуулсан санал асуулгын судалгаагаар малчдын 70 орчим хувь нь бэлчээрээ гэрээгээр ашиглахыг дэмжжээ. 2009-2012 онд Мянганы сорилтын сангийн

шугамаар ойт хээр, хээрийн бүсийн 5 аймагт хэрэгжсэн “Хот орчмын бэлчээр” төслийн хүрээнд бэлчээрийг гэрээгээр ашиглуулахаар санал тавихад төслөөр төлөвлөсөн тооноос хоёр дахин илүү малчдын бүлэг саналаа ирүүлснээс 386 бүлэгт бэлчээрийг нь гэрээгээр олгосон байна. Энэхүү төслөөр 4 улирлаар сэлгэж нүүдэг шинж чанарыг алдагдуулалгүйгээр төсөлд хамрагдах болон хөрш малчдын эрх ашигт нийцүүлэн аливаа зөрчил, маргаангүйгээр бэлчээрийг гэрээгээр олгож болохыг нотлон харуулсан байна. 2012 онд сонгодог говийн бүс болох Өмнөговь аймгийн Ханбогд суманд явуулсан судалгаагаар малчин өрхийн 78 хувь нь бэлчээрийг гэрээгээр ашиглуулахыг дэмжсэн, 10.8 хувь нь сайн ойлгохгүй, 9.7 хувь нь мэдэхгүй, 1.6 хувь нь дэмжихгүй гэсэн хариулт өгсөн байна. Ийнхүү бэлчээрээ гэрээгээр ашиглах нь малчдын хэрэгцээ болж, гэрээгээр ашиглуулахад төвөгтэй гэж үздэг Говийн бүсэд ч зохицуулалтаа шаардах болсныг энэхүү судалгаа харуулж байна.

### Гэрээгээр ашиглуулснаар ямар эрх ашиг хохирох вэ?

1. Манай орны газар нутгийн дийлэнхийг эзэлдэг бэлчээрийг нийтээр дундаа ашиглах нэрийдлээр “уугуул эзэн” болсон малчдын эрх зүйн чадамжийг нь хүчгүйдүүлсэн өнөөгийн тогтолцоонд бэлчээрийн газрыг хувийн болон салбарын явцуу эрх ашигт нийцүүлэн дур зоргоор олгох явдал газар авсан. Бэлчээрийн газраас таслан авдаг гаднын болон үндэсний уул уурхай, аялал жуулчлалын компаниуд, үүнд нь үйлчилж “ашиг” хүртдэг төв, орон нутгийн албан тушаалтнуудын явцуу эрх ашиг хохирно.
2. Өнөөгийн засаглалын хомсдолыг ашиглан бэлчээрийг сорчилдог, муутгаж хаядаг, ашиглалтаа дур зоргоор тэлдэг, үүнд нь өртөж хохирогчдын эрх ашгийг үл ойшоодог, орон нутгийн албан тушаалтнуудтай сүлбэлддэг нутгийн “тамгагүй ноёдын” эрх ашиг хохирно. Орон нутагтаа нөлөөтэй, шагнал ямбатай, ихэнх тохиолдолд манай түшээдийн очиж уулздаг, дуу хоолойг нь сонсдог, энэ утгаараа нийт малчдын дуу хоолой мэт сонсогддог нэн цөөнхийн эрх ашиг яригдаж байгаа хэрэг. Өнөөгийн нийгмийн чинээлэг хэсгийн өвөрмөц төлөөлөл болсон олон тооны тавиул малтан иргэд, уяачид ч энэ ангилалд багтан “хохирох” магадлалтай.
3. Монгол орны бэлчээрийн мал аж ахуй нь экологийн хувьд харьцангуй цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдгээрээ олон улсын зах зээл дээр өрсөлдөх өндөр чадавхтай. Түүний зэрэгцээ нэг малчдын малаа аж ахуйн эргэлтэд оруулж борлуулах хөшүүрэг хангалтгүйгээс хот суурин газрын мах, сүүний хомсдол архагшиж, үнэ өссөнөөр эрчимжсэн МАА-д хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж байна. Мал аж ахуйд хөрөнгө оруулах нь мэдээж бэлчээргүйгээр бүтэхгүй, ашгийн төлөө ажилладаг компаниуд бэлчээрийг бас л үнэгүй, төвөг яршиггүй авах сонирхолтой. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулбал энэхүү ашиг сонирхол “хохирно”.

### Явцуу эрх ашгийг нийтлэг эрх ашигт нийцүүлэх буюу хохирогчийг хожигч болгох нь

1. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах нь малчдын ашиг орлогоо нэмэгдүүлэх гэсэн сонирхлыг хавчих бодлого биш юм. Харин ч байгалийн эрсдэлээс үл хамааран орлого, хөрөнгө нь тогтвортой нэмэгддэг, чанар, бүтээмж, өрсөлдөх чадвар нь сайжирсан тогтвортой хөгжил бүхий МАА-н салбар, малчдын тогтвортой амьжиргааг бий болно. Бүтээгдэхүүний тоо, чанарын өсөлт нь хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг дээшлүүлж, үнийн өсөлтөөс сэргийлнэ.
2. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах нь малчдын чинээлэг давхаргын эсрэг ч юм уу МАА-д хөрөнгө оруулалтыг хавчих гэсэн бодлого биш юм. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулахдаа одоо байгаа малын толгойн тоо, ашиглаж байгаа бэлчээрийг нь суурь болгох тул чинээлэг

малчдын бэлчээрийн эрх ч нэгэн адил баталгаажиг хамгаалагдана. Гагцхүү өөрсдийн нөлөө, хэлхээ холбоог ашиглан бэлчээрийг сорчлон ашигладаг, бусдыг хохироон шахаж, бэлчээрээ тэлж малаа өсгөдөг буруу практикийг халж, сайн засаглалын зарчимд нийцүүлэх юм. Сайн засаглал нь хууль дээдлэх, ил тод байх, эрх ашиг нь хөндөгдөгсдийн оролцоог хангах, тэдний өмнө хариуцлага хүлээдэг байх гэсэн гол дөрвөн зарчмыг л шаарддаг. Баян, ядуу, тавиул малтан, эрчимжсэн МАА-д шинээр хөрөнгө оруулагч хэн ч бай бэлчээрийн эрхээ тэлж л байгаа бол үүнээс болоод хохирогч байгаа эсэхэд ил тод үнэлгээ хийдэг, тэдний эрх ашгийг оролцуулж, харгалзан үздэг, хохиролгүй болгох асуудлыг л хуульчилна гэсэн үг. Өөрөөр хэлбэл нийгмийн шударга ёсонд нийцүүлэн хуулийн хүрээнд ашиг орлогоо нэмэгдүүлж болдог, бусдын эрх ашгийг түүний дотор үе үеийнхний өмч болсон газрын чанарыг хадгалах төрийн эрх ашгийг дээдлэх зарчмыг л мөрдүүлнэ гэсэн үг. Энэхүү зарчим бэлчээрээс газар авч байгаа уул уурхай, аялал жуулчлал, барилга, дэд бүтцийн компаниудад нэгэн адил мөрдөгдөнө. Бэлчээрээ алдана гэдэг нь зөвхөн өвөлжөө, хаваржаагаар хязгаарлагддаггүй, улирлын болон отрын нөөц нутагт орох эрхээ хязгаарлуулсан, зам шугам сүлжээгээр таслуулсан гээд олон хэлбэртэй бөгөөд үүнд өртсөн малчид хохирлоо барагдуулах эрх зүйн орчингүй байна. Тэдний хохирлыг тооцож, нөхөн барагдуулах нь жудагтай ямар ч салбар, бизнесийн энгийн ёс зүй болох учиртай. Дүгнэж хэлбэл зохицуулалтгүй орчинд өөгшин доройтох “хохирогчдыг” сэхээрүүлж, хууль, шударга ёсонд нийцсэн хожигч болгох тухай л асуудал юм.

3. Бэлчээрийн газар олголт, шилжүүлэх эрх мэдэл албан тушаалтнуудын гарт байгаа цагт авлигын асуудал шийдэгдэхгүй болох нь практикаар нотлогдоод байна. Иймд авлигад амташсан үйлдлээс улбаалсан бэлчээрийг гэрээгээр ашиглуулахын эсрэг ил, далд лоббид үл автан асуудлыг нэг мөр цэгцлэх нь нийтийн эрх ашиг юм.

Бэлчээрийг гэрээгээр ашиглуулахын эсрэг “хадны мангаа” ба үнэн учир. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулна гэдэг нь хувааж өгөөд, хашаад эхлэх юм, ингээд нүүдэл суудал байхгүй болж, довон дээрээ үхэх сэхэхээ үзэх юм байна, зөрчил, маргаан дэвэрч, бэлчээрийн мал аж ахуй устах нь гэсэн буруу ойлголт санаатай болон санамсаргүйгээр энд тэнд хэлэгдэж, хадны мангаа шиг айлгаж явна. Энэ бол Монгол орны нөхцөлд таарахгүй, үндсээрээ буруу ойлголт. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулахын үндсэн зорилго нь өнөөгийн зохисгүй ашиглалтыг халж, бэлчээрийг улирлаар хуваарьтай ашиглаж, ган, зудын үед орох нөөц нутагтай байсан шилдэг уламжлалыг сэргээн тогтоож, түүнийг гэрээний үндсэн дээр дагаж мөрдүүлдэг болгоход чиглэнэ. Энгийнээр хэлбэл малчид нэг дор хоригдох биш, харин дөрвөн өөр газар улирлын бэлчээр гэрээгээр ашиглаж, ган, зудын үед нөөц нутаг ашиглах эрхийг нь албан ёсны болгон баталгаажуулж байгаа хэрэг юм.

Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах зөв үзэл баримтлал нь дараах зүйлд оршино. Үүнд:

1. Тухайн суманд бэлчээрийг гэрээгээр ашиглуулах асуудлыг гаднаас хүн ирээд хуваагаад өгөх биш, аль бэлчээрийг гэрээгээр хэрхэн ашиглуулах вэ гэдгийг малчид хот айл, хэсэг, бүлгээрээ хэлэлцэж, нэг ч малчин өрхийн одоогийн ашиглаж байгаа улирлын болон отрын бэлчээрийн эрхийг таналгүйгээр шийднэ.
2. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах нь түүнийг ашиглаж ирсэн уламжлал, албан бус зөвшилцлийн механизмуудтай зэрэгцэн оршино.

3. Ган, зудын үед ашиглах орон нутгийн отрын нөөц нутгийг хэлэлцэн тогтоож, ашиглах журмыг ИТХ-р батлуулан мөрдөнө. Отрын нөөц нутагт мал оруулахдаа түүний даацыг хэтрүүлж, туурайн зуд болгохгүй байх зарчим баримтална.
4. Тухайн бүлэгт гэрээгээр ашиглуулах бэлчээрийн хил доторх бүх малчин өрхийг заавал хамруулах бөгөөд нэг ч өрхийг бүлгийн гишүүнчлэлээс гадуур орхиж, бэлчээр ашиглах эрхийг нь хаан боогдуулахгүйгээр зохион байгуулна.
5. Одоогийн ашиглаж байгаа хэв маягийг аль болох хөндөхгүй байх, үүний тулд гэрээгээр ашиглах субъектийг малчны бүлгийн түвшинд шийдэх нь өрх бүрийн ашиглах бэлчээрийг тооцох эмзэг асуудлыг хөндөлгүй тойрч гарах практик шийдэл юм. Гэхдээ бүлгийн гэрээгээр ашиглах бэлчээр дотроо малчин өрх, хот айл нь өөрийн өвөлжөө, хаваржаагаа эзэмшээд явна.
6. Цаг агаараас хамааруулан жил бүр тогтоох бэлчээрийн даацад малын ачааллыг уялдуулах нь гэрээгээр ашиглагчийн үндсэн үүрэг байна.
7. Ган, зуд болсон нөхцөлд аргагүй нөхцөлд малчид бэлчээрийн даацаас хэтрүүлэлгүйгээр бусдын нутагт орох эрх эдэлж, бусдыгаа оруулах үүрэг хүлээнэ. Сумын захиргаа ч гаднын малыг оруулах зөвшөөрөл олгохдоо хэчнээн мал оруулах бололцоотой болохыг гэрээ байгуулсан малчидтай зөвшилцөж байж шийдэх зарчим барина.
8. Эрчимжсэн болон хагас эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд зориулж бэлчээрийг улирал харгалзахгүйгээр малчдын бүлэг, иргэн, аж ахуй нэгжид гэрээгээр ашиглуулах замаар хөгжлийг нь дэмжинэ.
9. Гэрээг зөвхөн өвөл-хаврын улирлаар хязгаарлалгүй бүх улирлын бэлчээрийг хамруулж, зөвхөн хүсэлт гаргавал Засаг дарга гэрээ байгуулдаг үлбэгэр тогтолцоог өөрчилж, нийт малчдыг хамруулан гэрээ байгуулахыг Засаг даргад хариуцуулна.
10. Малын тоо толгойн албан татварын орлогоос малыг аж ахуйн эргэлтэд оруулсны урамшууллыг олгох замаар малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх эдийн засгийн хөшүүргийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах нь нийтийн эрх ашгийн эрхэм эрэмбэ. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулснаар:

1. Бэлчээр эзэнтэй болж, зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах хөшүүрэг бий болно.
2. Ашиглуулах бэлчээрийн хил заагийг тогтоосноор малын тоог хязгааргүй өсгөх биш харин эдийн засгийн эргэлтэд оруулж борлуулах, ашиг шим, чанарыг эрхэмлэх сэтгэлгээ төлөвшинө.
3. Мал аж ахуйг чанар, бүтээмжид суурилсан тогтвортой хөгжлийн замд оруулж, МАА-н өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангаж, үнийн өсөлтөөс сэргийлнэ.
4. Бэлчээрийн эдэлбэрээс бусад эдэлбэрт шилжихэд малчид, МАА-н салбарын эрх ашгийг хөгжлийн бодлоготой уялдуулан зохистой харгалздаг нөхцөлийг бүрдүүлнэ.

**Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах нь ийнхүү амьдрал дээр хариугаа нэхсэн Монгол орны хөгжлийн тулгамдсан олон асуудлын шийд болоод байна. Энэ асуудлыг шийдвэрлэхэд эрх ашгийн эрэмбээр хандаж, нийтийн эрх ашгийг дээдэлцгээе.**

УИХ-д өргөн барьсан Газрын тухай багц хуулийн одоогийн төслөөр отрын бэлчээрээс бусдыг нийтээр ашиглана гэсэн нь ядаж өвөл-хаврын бэлчээрийг гэрээгээр ашиглах зохицуулалттай Газрын одоогийн хуулиа ч дордуулах төдийгүй бэлчээрийг түрээсээр,

гэрээгээр ашиглуулах зохицуулалт бүхий Иргэний хууль, Байгаль орчныг хамгаалах тухай гээд олон хуультай зөрчилдөж буйг ч анхаарах шаардлагатай юм.

## **БОДЛОГО СУДЛАЛЫН ТӨВ**